**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,**
**ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

# ОЁМОЛ БҮТЭЭГДЭХҮҮН, ХУВЦАС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ГАРЦ ШИЙДЭЛ

**2019.10.21**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ОЁДЛЫН САЛБАРЫН

# АГУУЛГА


1 ОЁМОЛ БҮТЭЭГДЭХҮҮН, ХУВЦАС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ТАЛААР

2 ОЁМОЛ БҮТЭЭГДЭХҮҮН, ХУВЦАС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

3 ОЁДЛЫН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

4 ДЭВШҮҮЛЖ БУЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

# ОЁМОЛ БҮТЭЭГДЭХҮҮН, ХУВЦАС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ТАЛААР




Улсын хэмжээнд бүх төрлийн масс үйлдвэрлэлийг дэмжсэн бодлого, хууль эрх зүй, хөрөнгө оруулалт, чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ажиллагсдын ажлын орчин нөхцөл болон нийгмийн асуудлыг дэмжсэн, ИТА, хүний нөөцийг бэлтгэх төрийн урт хугацааны тогтвортой бодлого байхгүй байна. Хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх олон хууль, эрх зүйн баримт бичгүүд, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгаа хэдий ч оёдлын салбарт чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ байхгүй.

Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбар нь ноос, ноолуур, арьс ширэн болон түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгон нэмүү өртөг хамгийн их шингээдэг үйлдвэрлэлийн салбар юм. Манай салбар харьцангуй бага хөрөнгө оруулалтаар олон хүний ажлын байр бий болгодог. Нийгмийн өндөр үр өгөөжтэй, онцлог, чухал салбар юм.

Иймээс урт болон богино хугацааны тасралтгүй бодлогоор оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага байна.

# ОЁМОЛ БҮТЭЭГДЭХҮҮН, ХУВЦАС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хууль, бодлого, хөтөлбөр



Үр дүн

Өнөөгийн байдал



Үр дүн



- Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль / 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр/
- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль /2019 оны 06 сарын 06 өдөр/
- Монгол Улсын Засгийн газрын 90 дугаар тогтоол, Жагсаалт шинэчлэн батлах тухай /2019 оны 2 дугаар сарын 27-ны өдөр/
- Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого /Монгол Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоолын хавсралт/
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал /2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр/
- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хөтөлбөр

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

ОЁДЛЫН САЛБАРЫН

# ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Өрхийн болон Жижиг, үйлдвэр

- Олон тоогоор үйлдвэрлэх боломжгүй
- Маш бага тооны 1-10 хүртэлх ажлын байр
- Цалин, үнэлгээ бага
- Нийгмийн асуудал шийдэх боломжгүй
- Хөгжиж, өргөждөггүй
- Масс үйлдвэрт ажиллах сонирхолгүй
- Тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй
- Улс орны эдийн засагт оруулах хувь нэмэр маш хангалтгүй

- Хууль эрх зүйн орчин
- Түүхий эд, туслах материалын хараат
- Татварын орчин
- Хөрөнгө оруулалтын байдал
- Зах зээл хамгаалалтгүй

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ОЁДЛЫН САЛБАРЫН

# ОЁМОЛ БҮТЭЭГДЭХҮҮН, ХУВЦАС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА



Хөрөнгө оруулалт үр дүнтэй, оновчтой болно.



Масс үйлдвэрлэлийг нэмэгдэнэ



Бүтээгдэхүүний өртөг, үнэ буурах



Боловсон хүчин, ажиллагсдын цалин хангамж нэмэгдэнэ



Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, чанар сайжирна.



Эрүүл, аюулгүй орчин ажиллах таатай орчин бүрдэнэ.



ИТА-наар суралцагсад нэмэгдэнэ.




Дотоод зах зээлийг хангах болон экспорт нэмэгдэх, гадаад захиалга авах боломжтой



Улсад орох татварын орлого нэмэгдэнэ

Масс үйлдвэрлэл хөгжиж, дотоод зах зээлээ хангах, экспорт нэмэгдэж олон улсад хүлээн зөвшөөрөгдөж захиалга нэмэгдэж улсад нийгэм эдийн засагт чухал нөлөө үзүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ОЁДЛЫН САЛБАРЫН

# ДЭВШҮҮЛЭХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбарт хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх
- Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг шинэчлэн найруулж боловсруулан батлуулах
- Дотоодод үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнтэй ижил төстэй бүтээгдэхүүний импортын татварыг нэмж /30-аас доошгүй хувь болгох/, үндэсний үйлдвэрлэгчдийн зах зээлийг хамгаалах
- Оёмол бүтээгдэхүүний түүхий эд болон тоног төхөөрөмжийг гааль НӨАТ-аас чөлөөлөх
- Масс үйлдвэрлэлийг дэмжсэн хууль, эрх зүй, хөрөнгө оруулалт, татварын бодлогоор дэмжих
- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бүх компани, аж ахуйн нэгжүүд хөдөлмөр хамгааллын болон дүрэмт хувцасаа дотоодын үйлдвэрүүдээс авах хууль тогтоомжуудыг гаргах.
- Үйлдвэрүүд чадваржих, өсөж дэвших боломжоор хангаж НӨАТ-аас 5 хүртлэх жил чөлөөлөх, цаашид үе шаттайгаар өсгөх.
- Дотоодын үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний зарж борлуулж буй худалдаа эрхлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, зах болон худалдааны төвүүдээр борлуулалтыг НӨАТ-ын баримт заавал олгодог болгох

- Үйлдвэр эрхлэн нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, ажлын байр бий болгож буй аж ахуйн нэгжүүдэд урт хугацаатай хөнгөлөлттэй зээлээр дэмжих. Төслийг гүйцэтгэлээр нь үе шаттай хяналттай олгох.
- Үндэсний хувцасны хэрэглээг дэмжиж долоо хоногийн 1 өдрийг үндэсний хувцастай өдөр болгох тогтоол шийдвэр гаргах
- Ажиллах хүч, хүний нөөц дутагдалтай тул буурай орнуудаас хямд өртөгөөр ажиллах хүчийг оруулж ирэх хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгох,
- Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын 4.1.5 дээр багш мэргэжлээс гадна инженер мэргэжлийг нэмэх, ИТА-ийг олноор бэлтгэх
- ИТА-ны чиглэлээр элсэгчдийг нэмэгдүүлэхэд анхаарч ажил олгогч, их дээд сургууль, ХНХЯ, ХХААХҮЯ хамтран холбогдох хууль эрх зүйн зохицуулалтыг боловсруулах
- Салбарын ажиллагсдын ур чадвар, үнэлэмжийг бий болгох, цалин урамшуулалын тогтолцоог уялдуулах
- Үйлдвэрлэлийг жижиг дунд, масс үйлдвэрлэлийг ангилах, үйлдвэрлэлд стандартыг бий болгох,
- Салбарын холбоодын тухай хуулийг боловсруулан, батлуулах үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалах, салбарын бодлогыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх үйл ажиллагаа, эрх, үүргийг тодорхой болгох

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА